



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Сүхбаатар аймгийн Бичигт хөгжил ОНӨААТҮГ-ын 2023 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: СБА-2024/17/НА-СТА-ОНА

Цахим хуудас:
www.audit.mn
Баруун-Урт хот
2023 он

Дарга,
тэргүүлэх аудитор: М.Нарантуяа
Утас: 70518396
Аудитын менежер: Г.Даваа
Утас: 70512123
Аудитор: Ө.Золзаяа
Утас: 70512123

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



СҮХБААТАР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

22000 Баруун-Урт сум, Сүхбаатар аймаг
Утас: 70518396, Факс 70518396
E-mail: Sukhbaatar@audit.gov.mn

СҮХБААТАР АЙМГИЙН БИЧИГТ
ХӨГЖИЛ ОНӨААТҮГ-ЫН ЗАХИРАЛ
Н.АРИУНТУНГАЛАГ ТАНАА

2024.03.15 № 229
танай _____ - ны№ _____ -т

Сөрөг дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Бичигт хөгжил ОНӨААТҮГ-ын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудад аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан буруу илэрхийлэл нь санхүүгийн тайланд материаллагаар нөлөөлсөн бөгөөд өргөн тархсаныг хангалттай, зохистой аудитын нотолгоонд үндэслэн нотолсны улмаас Бичигт хөгжил ОНӨААТҮГ -ын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулаагүй гэж үзсэн.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Бичигт хөгжил ОНӨААТҮГ нь тайлант оны өглөг, авлагыг тооцоо нийлж баталгаажуулаагүй, анхан шатны баримтын бүрдэлгүй ажил гүйлгээг хийж, тайланд илэрхийлсэн, нийгмийн даатгалын тайланг үнэн зөв тайлагнаагүй, бараа материалын тайлан гаргаж баталгаажуулаагүй, шилэн дансны цахим системд бүртгүүлэн мэдээллийг ил тод байршуулж мэдээлээгүй, санхүүгийн үйл ажиллагаанд тавих дотоод хяналтын систем хэрэгжихгүй байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, тайлант хугацааны ажил гүйлгээний анги, дансны үлдэгдлийн холбогдох тодруулгын тохиолдсон байх, иж бүрэн байх, үнэлгээ ба хуваарилалт, тасалбар болголт, оршин байх, эрх ба үүрэг зэрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна.

D:/Bichig hereg/2023/A4 toot

Асуудлыг онцолсон хэсэг

Бичигт хөгжил ОНӨААТҮГ-ын Улсын бүртгэлийн гэрчилгээний үйл ажиллагааны чиглэлд 2023 оны 8 дугаар сарын 15-ны өдөр зочид буудлын үйлчилгээ, гэрэлтүүлэг, нийтийн хоолны үйлчилгээ гэсэн нэр төрлийг нэмж бүртгүүлсэн байна.

Аудитын гол асуудал

Тайлант онд Бичигт хөгжил ОНӨААТҮГ аймаг орон нутгийн төсвөөс 20,000.0 мянган төгрөгийн санхүүгийн дэмжлэг авч, дулааны эрчим хүчээр хангах үйлчилгээ болон түрээсийн орлого 24,307.0 мянга, бусад үйл ажиллагааны орлого 15,102.3 мянган төгрөгийн орлогыг тус тус төвлөрүүлж, 69,663.1 мянган төгрөгийг зарцуулсан байна.

Бусад асуудлын хэсэг

Сүхбаатар аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар Бичигт хөгжил ОНӨААТҮГ-ийн 2023 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг батлуулаагүй байна.

Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага

Удирдлага нь санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.


Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Г.ДАВАА

D:/Bichig hereg/2023/A4 toot

2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Код	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	34,420,563.68	11,855,630.68
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	11,597,153.68	1,343,880.68
31200	Банкинд байгаа бэлэн мөнгө	11,597,153.68	1,343,880.68
31210	Төгрөг	11,597,153.68	1,343,880.68
31213	Арилжааны банк дахь харилцах	11,597,153.68	1,343,880.68
33	АВЛАГА	0	3,690,000.00
33500	Бусад авлага	0	3,690,000.00
33510	Байгууллагаас авах авлага	0	3,690,000.00
35	БАРАА МАТЕРИАЛ	22,823,410.00	6,821,750.00
35400	Хангамжийн материал	22,823,410.00	6,821,750.00
35470	Бусад хангамжийн материал	22,823,410.00	6,821,750.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	0	12,635,833.32
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	0	12,635,833.32
39200	Биет хөрөнгө	0	12,635,833.32
39205	Машин тоног төхөөрөмж(компьютер)	0	1,320,000.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	0	-290,000.04
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	0	12,550,000.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	0	-944,166.64
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	34,420,563.68	24,491,464.00
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	773,500.00	19,197,750.00
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	773,500.00	19,197,750.00
41200	Богино хугацаат зээлийн өглөг	0	9,900,000.00
41210	Төгрөг	0	9,900,000.00
41214	Төрийн өмчит аж ахуйн нэгжүүдийн зээл	0	9,900,000.00
41300	Өглөг	773,500.00	1,175,250.00
41360	Бусад өглөг	773,500.00	1,175,250.00
41364	НДШ-ийн өглөг /ТӨҮГ/	773,500.00	1,175,250.00
41400	Урьдчилж орсон орлого	0	8,122,500.00
41440	Бусад урьдчилж орсон орлого	0	8,122,500.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	33,647,063.68	5,293,714.00
51	Засгийн газрын хувь оролцоо	33,647,063.68	5,293,714.00
51200	Хуримтлагдсан үр дүн	33,647,063.68	5,293,714.00
51210	Өмнөх үеийн үр дүн	5,921,107.00	30,865,764.11
51220	Тайлант үеийн үр дүн	27,725,956.68	-25,572,050.11
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	34,420,563.68	24,491,464.00

2.2 Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	82,450,000.00	27,171,390.11
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	82,450,000.00	27,171,390.11
120	Нийтлэг татварын бус орлого	82,450,000.00	27,171,390.11
120010	Борлуулалтын орлого (Цэвэр) /ТӨҮГ/	82,450,000.00	51,029,235.89
120011	Борлуулалтын өртөг /ТӨҮГ/	0	23,857,845.78
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	54,724,043.32	52,743,440.22
21	УРСГАЛ ЗАРДАЛ	54,724,043.32	52,743,440.22
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	54,724,043.32	52,743,440.22
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	54,724,043.32	52,743,440.22

210811	Ерөнхий ба удирдлагын зардал /ТӨҮГ/	54,724,043.32	51,583,724.85
210814	Орлогын татварын зардал /ТӨҮГ/	0	1,159,715.37
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	27,725,956.68	-25,572,050.11
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	27,725,956.68	-25,572,050.11

2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
1	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	0	0	5,921,107.00	5,921,107.00
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0	0	0.00	0.00
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	0	0	5,921,107.00	5,921,107.00
4	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	0	0	0.00	0.00
9	Тайлант үеийн үр дүн	0	0	27,725,956.68	27,725,956.68
10	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	0	0	33,647,063.68	33,647,063.68
11	2023 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	0	0	33,647,063.68	33,647,063.68
12	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0	0	-2,781,299.57	-2,781,299.57
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	0	0	30,865,764.11	30,865,764.11
18	Зарласан ногдол ашиг	0	0	0.00	0.00
19	Тайлант үеийн үр дүн	0	0	-25,572,050.11	-25,572,050.11
20	2023 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	0	0	5,293,714.00	5,293,714.00

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	82,450,000.00	57,239,235.89
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	82,450,000.00	57,239,235.89
120	Нийтлэг татварын бус орлого	82,450,000.00	57,239,235.89
120013	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого /ТӨҮГ/	8,100,000.00	37,239,235.89
120017	Татаас, санхүүжилтийн орлого /ТӨҮГ/	74,350,000.00	20,000,000.00
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	72,354,453.32	67,492,508.89
21	УРСГАЛ ЗАРДАЛ	72,354,453.32	67,492,508.89
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	72,354,453.32	67,492,508.89
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	72,354,453.32	67,492,508.89
210818	Бусад мөнгөн зарлага /ТӨҮГ/	72,354,453.32	67,492,508.89
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	10,095,546.68	-10,253,273.00
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	10,095,546.68	-10,253,273.00
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	1,501,607.00	11,597,153.68
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	11,597,153.68	1,343,880.68

3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 21,741.5 мянган төгрөгийн зөрчил¹ илэрснээс 21,741.5 мянган төгрөгийн зөрчилд 4 албан шаардлага хүргүүлж, зорилтот түвшин, нийгэм эдийн засгийн үндсэн үзүүлэлттэй холбоотой 1 зөвлөмж хүргүүлээ.

Мөн тайлант оны өглөг, авлагыг тооцоо нийлж баталгаажуулаагүй, анхан шатны баримтын бүрдэлгүй ажил гүйлгээг хийж, тайланд илэрхийлсэн, нийгмийн даатгалын тайланг үнэн зөв тайлагнаагүй, бараа материалын тайлан гаргаж баталгаажуулаагүй, шилэн дансны цахим системд бүртгүүлэн мэдээллийг ил тод байршуулж мэдээлээгүй, санхүүгийн үйл ажиллагаанд тавих дотоод хяналтын систем хэрэгжихгүй байгаа зөрчлүүд нь санхүүгийн тайланд материаллаг ба өргөн тархсан тул “Сөрөг” дүгнэлт өгсөн тул “Бичигт хөгжил” ОНӨААТҮГ-ын захирал Н.Ариунтунгалагт хариуцлага тооцуулах албан тоотыг аймгийн Засаг даргад хүргүүллээ.

3.1 Албан шаардлага

3.1.1 Дулаан халаалтын төлбөрийн 3,690.0 мянган төгрөгийн авлагыг харилцагч иргэнтэй тооцоо нийлж баталгаажуулаагүй.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.3 (*төсвийн гүйцэтгэлийг хууль тогтоомжийн дагуу хэрэгжүүлж, тайлагнах*), Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.6 (эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах) дахь заалтуудыг зөрчсөн ба иж бүрэн байх, ангилал, үнэлгээ ба хуваарилалт батламж мэдэгдлийг хангахгүй байна.

3.1.2 Санхүүгийн анхан шатны баримтын бүрдэл дутуу 18,081.5 мянган төгрөгийн ажил гүйлгээ хийж, иж бүрэн байх батламж мэдэгдлийг мөрдөж ажиллаагүй байна. Үүнд:

- Эрх бүхий албан тушаалтнаар баталгаажуулсан томилолтын баримт, үр дүнг тайлагнасан илтгэх хуудас болон бусад холбогдох баримтын бүрдэл дутуу 1,315.2 мянган төгрөгийг санхүүгийн тайлангийн албан томилолтын зардалд илэрхийлсэн

- Бараа материал худалдан авсан 1,864.5 мянган төгрөгийн баримтыг монгол хэлээр гаргаж, санхүүгийн баримтад хавсаргаагүй

- Хүнсний материал, шатахуун, тавилга эд хогшил, бичиг хэрэг, аж ахуйн материал болон бусад зардлыг нотлох гэрээ, нэхэмжлэх, е-баримт, төлбөр төлсөн баримтын иж бүрдэл хангалтгүй байхад 14,901.9 мянган төгрөгийн гүйлгээ хийж тайлагнасан.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1 (Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно), 13.7 (Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно) Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2 дахь хэсгийн 41.2.3 (*төсвийн гүйцэтгэлийг хууль тогтоомжийн дагуу хэрэгжүүлж, тайлагнах*) дахь заалтуудыг зөрчсөн ба иж бүрэн байх, нийцсэн ба зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

3.1.3 Бараа материалын бүртгэлийг аккурэл сууриар бүртгээгүй, СС-ын баталсан маягтаар бараа материалын тайланг эдийн засгийн ангилал бүрээр гаргаж, баталгаажуулаагүй нь ажил гүйлгээний анги, дансны үлдэгдэл тодруулгын иж бүрэн байх, тасалбар болголт батламж мэдэгдлийг хангаагүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.3 (Нягтлан бодох бүртгэлийн мэдээлэл боловсруулах ажиллагааг дараах дарааллаар гүйцэтгэнэ), 20 дугаар

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

зүйлийн 20.2.3 (холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах) дахь заалтуудыг зөрчсөн байна.

3.1.4 Шилэн дансны цахим системд бүртгүүлж, холбогдох мэдээллийг байршуулаагүй нь нийцсэн ба зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1 (Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага, албан тушаалтан дараах мэдээллийг тогтмол мэдээлнэ), 6.4 (Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага дараах мэдээллийг долоо хоногийн дотор мэдээлнэ) дах заалтуудад нийцэхгүй байна.

3.2 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Санхүүжилтэй холбоотой асуудал

Илрүүлэлт:

2023 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг гаргаж аймгийн ИТХ-аар батлуулаагүй.

Өгсөн зөвлөмж: 2024 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг гаргаж аймгийн ИТХ-аар батлуулах.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2024 оны 08 дугаар сарын 01-ний өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Орлогыг дутуу тайлагнасан	1	125,093.7			1	125,093.7	1	125,093.7				
Дүн	1	125,093.7			1	125,093.7	1	125,093.7				

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
									Тоо	Дүн	Тоо	Дүн
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
										Албан тушаалтны тоо		

Авлагыг тооцоо нийлээгүй	1	3,960.0			1	3,960.0						
Анхан шатны баримтын бүрдэлгүй гүйлгээ хийсэн	1	18,051.5			1	18,051.5						
Бараа материалын тайлан гаргаагүй	1	-			1	-						
Шилэн дансны цахим сайтад мэдээллийг байршуулаагүй	1	-			1	-						
Зорилтот түвшнийг батлуулаагүй	1	-					1	-				
Сөрөг дүгнэлт-хариуцлага тооцох	1	-							1	1		
Дүн	6	21,741.5			4	21,741.5	1	-	1	1		